



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 1/91

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээнд хяналт тавьж ажиллах Төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах болон Хот тосгон ба суурин газрын гудамж талбайн гэрэлтүүлгийн стандартыг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Энэ тушаалын 1 дүгээр зүйлд заасан ажлуудын худалдан авах ажиллагааг хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Т.Хэрлэн/-нд даалгасугай.


3. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж хяналт тавьж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/-т даалгасугай

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Ф.ГАНТӨМӨР



1110300292

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 09 дугаар сарын 09 өдрийн
1191 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, Санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Энхбат	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн